



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 17 өдөр

Дугаар 2123

Чингис хот

Эд хөрөнгө актлах, худалдах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.2-ын "а" "б", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 54 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн өмчит 4 байгууллагын 97 010 500 төгрөгийн балансын үнэтэй, 69 015 071 төгрөг 99 мөнгөний хуримтлагдсан элэгдэлтэй, 27 995 428 төгрөг 01 мөнгөний үлдэх өртөгтэй актлах 9 нэр төрлийн эд хөрөнгийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Орон нутгийн өмчит 2 байгууллагын 70 000 000 төгрөгийн балансын үнэтэй, 59 333 333 төгрөг 48 мөнгөний хуримтлагдсан элэгдэлтэй, 10 666 666 төгрөг 52 мөнгөний үлдэх өртөгт 3 нэр төрлийн хөрөнгийг худалдахаар хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Худалдах хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч:

Н. Үнэнбат

Орон нутгийн өмчийн газрын даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Хөтлөгч:

С.Энхцэцэг

Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Тэмдэглэл хөтлөгч: Л.Оюунтуяа

Орон нутгийн өмчийн газрын нягтлан
бодогч, бичиг хэрэг

Өмч эзэмшигч байгууллагын төлөөлөл

4. Худалдах эд хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг 2020 оны 10 дугаар сарын 21-ний өдөр 11:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын 304 тоот өрөөнд зохион байгуулсугай

5. Эд хөрөнгийг актлах, худалдах ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Н.Үнэнбат/ -д даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

201910501

09 Аймгийн Засаг даргын 2020 оны
 дугаар сарын 07 өдрийн 4429
 дугаар захирамжийн хавсралт



Актлах эд хөрөнгийн жагсаалт

Д/д	Байгууллагын нэр	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Тоо хэмжээ	Ашигласан жил	нийт талбай	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл үнэ
1	Баянмөнх сум ЗДТГазар	Буурлын ухаан талбайн хашаа	2011.12.31	1	9	100 га	3,780,000	3,780,000	2,058,000	1,722,000
2	Норовлин сум ЕБСургууль	Хичээлийн 2 байр	2000.09.01	1	20	65	50,212,800	50,212,800	26,689,686.25	23,523,113.75
3	Норовлин сум ЗДТГазар	1-р багийн контор, сургууль	1983.02.01	1	37	60	10,953,600	10,953,600	10,953,600	0.00
		2-р багийн контор	1977.02.01	1	37	60	6,846,000	6,846,000	6,846,000	0.00
		1-р багийн клуб	1991.02.01	1	37	72	6,846,000	6,846,000	5,442,878.51	1,403,121.49
		3-р багийн контор	1986.02.01	1	37	60	11,410,000	11,410,000	10,613,356.08	796,643.92
		Нэг айлын орон сууц /3-р багийн төвд/	1986.02.01	1	37	20	6,846,000	6,846,000	6,368,013.65	477,986.35
4	Мөрөн сум Соёлын төв	Сүүдрэвч	2011.04.20	2			58,050	116,100	43,537.50	72,562.50
Нийт дүн				9			-	97,010,500	69,015,071.99	27,995,428.01